



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР

МЭДЭГДЭЛ

2024.01.24

Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын дэргэдэх допингийн Давж заалдах комисст М.Бадарчийн нэхэмжлэлтэй, Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага, Үндэсний их баяр наадам зохион байгуулах хороо, Үндэсний бөхийн салбар хороонд холбогдох үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэх (хэрэг хянан шийдвэрлэх) ажиллагаа явагдаж байгаа билээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэлхийн Допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу дэлхийн Допингийн эсрэг байгууллага ажиглагчаар оролцох бөгөөд урьдчилсан хуралдаан 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр болж, талуудаас гаргасан хүсэлт шийдвэрлэх, нотлох баримт цуглуулах зэрэг ажиллагаа явагдаж байна.

Үндсэн хуралдаан 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр товлогдсон бөгөөд эцсийн шийдвэр гараагүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа тул хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Монгол Улсын Арслан М.Бадарчийн нэхэмжлэлтэй хэрэг шийдвэрлэгдсэн, М.Бадарч ялалт байгуулсан” гэсэн агуулга бүхий мэдээлэл нь бүхэлдээ худал болохыг хариуцлагатайгаар мэдэгдэе.

Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Давж заалдах комиссын шийдвэрийн эх хувь, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх хураангуй тайлбар эсхүл үр дүнг тодорхойлсон хэвлэлийн мэдээг Давж заалдах комисс олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу хэвлэлийн мэдээг нээлттэйгээр хүргэх болно.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР
ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИСС